

2010 оны 01 дvгээр сарын 07-ны өдрийн УЗ-ийн хурлаар батлав.

## 1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Энэхvв журмын зорилго нь Монголын Бэлчээрийн Менежментийн Холбоо /цаашид холбоо гэх/-оос гишvнчлэлийн ангилал, гишvнний эрх, vүрэг, элсэлтийн хураамж, гишvнний татварын тухай болон гишvнчлэлийн асуудалтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

## 2. ГИШҮҮН

2.1. Гишvнчлэл нь хvндэт, тvнш, дэмжигч гэсэн ангилалтай байна.

2.2. Хvндэт гишvн нь Холбоог vүсгэн байгуулсан болоод Холбооны vйл ажиллагаанд vлэмж хэмжээний хувь хандив оруулсан (5 сая тогрогоос багагvй) хvн байна.

2.3. Тvнш гишvн нь холбооны vйл ажиллагааг дэмжиж, хамтран ажиллах иргэн, аж ахуйн нэгж байгууллага, гадаадын байгууллага байна.

2.4. Дэмжигч гишvн нь Холбооны vйл ажиллагааг дэмжигч Монгол улсын болоод гадаадын иргэн байна.

2.5. Гишvн нь холбооны дvрэм болон энэхvв журмыг хvлээн зовшоорсон байна.

## 3. ГИШҮҮНИЙ БҮРТГЭЛ

3.1. Холбооны гишvн болохыг хvсэгч нь холбооны байранд оорийн биеэр хvрэлцэн ирж, эсвэл албан ёсны цахим хуудсанд байрлуулсан бvртгэлийн анкетийг боглосноор бvртгэлд хамрагдана.

3.2. Гишvнээр бvртгvүлэхдээ холбогдох мэдээллvүдийг vнэн зов огох vүрэгтэй богоод оорийн зургийг хавсаргасан байна.

3.3. Гишvнний бvртгэл, гишvнчлэлтэй холбогдох асуудлыг холбооны менежер хариуцна.

#### **4.0000 ГИШҮҮНИЙ ЭРХ**

4.1. Гишүүний бүрэн эрх нь гишүүний бүртгэлд бүртгүүлэн элсэлтийн хураамж болон гишүүний татварыг толсноор хэрэгжиж эхэлнэ.

4.1.1. Холбооноос зохион байгуулж буй арга хэмжээнд урилгаар оролцох

4.1.2. Бэлчээрийн менежментийн талаарх шинэ мэдээ, мэдээллийг дэлгэрэнгүй авах,

4.1.3. Дотоодод зохион байгуулагдах бэлчээрийн менежментийн талаар зохион байгуулагдах семинар, уулзалтанд оролцох,

4.1.4. Гадаадад зохион байгуулагдах бэлчээрийн менежментийн салбарын олон улсын семинар, уулзалтын талаарх мэдээллийг дэлгэрэнгүй авах, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн тохиолдолд толоогчдийн бүрэлдэхвүнд оролцох,

4.1.5. Холбооноос эрхлэн гаргадаг “Ногоон алт” сонинг бүтэн жилийн турш үнэгүй захиалах,

4.1.6. Гишүүнчлэлийн татвар, түүний зарцуулалтын тайлантай холбоотой мэдээллийг авах, тайлбар шаардах,

4.1.7. Холбооны вйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалт, гишүүдийн эрх ашгийг хамгаалах талаар болон Холбооны чиг үүрэгт хамаарах асуудлаар мэдээлэл авах, санал, зовлогоо огох, шаардлага гаргах, жухам санаачлан боловсруулж, хэлэлцүүлэн, батлуулах, санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх,

4.1.8. Дүрмээр хүлээсэн зорилго, чиг үүргээ идэвхтэй, үр дүнтэй хэрэгжүүлэхийг Холбооноос шаардах.

#### **5.0000 ГИШҮҮНИЙ ҮҮРЭГ**

5.1. Холбооны зорилго, чиг үүргийг хэрэгжүүлэх вйл ажиллагаанд идэвхитэй оролцох.

5.2. Гишүүний татвар толоогүй бол саналын эрх эдлэхгүй байх.

5.3. Холбооноос зохион байгуулж буй арга хэмжээ, уулзалт, семинарт толоогччоо оролцуулах, оролцуулах боломжгүй бол энэ тухайгаа Холбоонд урьдчилан мэдэгдэх,

5.4. Хэлэлцэх асуудлаар гаргасан саналын хариуг цаг хугацаанд нь огох,

5.5. Холбоог толоолон ямар нэг вйл ажиллагаа явуулахгүй байх,

5.6. Холбооны дүрэм болон бvх гишүүдийн хурал, удирдах зовлоос гаргасан шийдвэр, уриалга болон хүлээж авсан үүргээ хугацаанд нь чанартай гүйцэтгэх, хэрэв боломжгүй гэж үзвэл тайлбараа бичгээр гаргах.

#### **6.0000 ГИШҮҮНИЙ ЭЛСЭЛТИЙН ХУРААМЖ, ЖИЛИЙН ТАТВАР**

6.1. Холбооны гишүүнээр бүртгүүлснээс хойш ажлын 5 хоногийн дотор гишүүний элсэлтийн хураамжийг толсон байна. Тухайн жилдээ жилийн татвараас чөлөөлөгдөнө.

6.2. Гишүүний татварыг нэг жилийн (365 хоногийн) хугацаатайгаар тогтоосон болно.

6.3. Гишүүний элсэлтийн хураамж, жилийн татвар нь гишүүнчлэлийн ангиллын дагуу ялгавартай тогтоогдсон болно.

Элсэлтийн хураамж:

6.3.1. Түнш гишүүн 500.000 тогрог, дэмжигч гишүүн 50.000 тогрог, их дээд сургууль, коллежийн бакалаврын зэргээр суралцагч оюутан, дунд сургуулийн сурагч бол 30.000 тогрог, малчин бол 20.000 тогрогийн элсэлтийн хураамж толно.

Гишүүний жилийн татвар:

6.3.2. Хүндэт гишүүн жилийн татвар толохгүй бөгөөд бүх насаараа холбооны гишүүн байна.

6.3.3. Түнш гишүүн 120.000 тогрог, дэмжигч гишүүн 30.000 тогрог, их дээд сургууль, коллежийн бакалаврын зэргээр суралцагч оюутан, дунд сургуулийн сурагч, малчин 10.000 тогрогийн татвар толно.

## **7.00 0 ГИШҮҮНД ОЛГОХ ШАГНАЛ УРАМШУУЛАЛ**

7.1. Холбооны вйл ажиллагаанд жинтэй хувь нэмэр оруулж, идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажилласан гишүүний амжилтыг нь үнэлж Тор засгийн шагналд тодорхойлно. Шагналд тодорхойлох болзолыг Холбооны Удирдах Зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

7.2. Бэлчээр хамгаалах, судлах чиглэлээр үр бүтээлтэй ажиллаж, холбооны вйл ажиллагаанд бодитой хувь нэмэр оруулсан гишүүнд Холбооны шагнал урамшууллыг олгоно. Шагналын торол болон болзолыг Холбооны Удирдах Зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

## **8.00 0 ГИШҮҮНЧЛЭЛ ДУУСГАВАР БОЛОХ**

8.1. Холбооны гишүүн оорийн хүсэлтээр эсвэл нас барсан, дүрэм ноцтой зорчсон бол гишүүнчлэл дуусвар болно.

8.2. Дараах зорчлуудийг холбооны гишүүнээс хасах ноцтой үндэслэл гэж үзнэ. Үүнд:

8.2.1. Тухайн гишүүн холбооны нэрийн дор хууль бус, оорт эрх нь олгогдоогүй эрхийг ашиглаж аливаа вйлдэл хийх,

8.2.2. Гишүүний татварыг нэг жилээс дээш хугацаагаар толоогүй бол,

8.2.3. Мэргэжлийн болон ёс зүйн дутагдал гаргаж, холбооны нэр хүндэд хохирол учруулсан бол.

8.3. Гишүүнчлэл нь дууссан гишүүний омоно нь толсон татвар, шимтгэл, хандив буцаан олгогдохгүй.